



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН УДИРДАМЖ

15170 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
4 дүгээр хороо, Ж.Самбуугийн гудамж,
Нийслэлийн засаг захиргааны III байр
Утас: 7011-1284, Факс: (976-11) 31-15-09
<http://www.ub.inspection.gov.mn>
E-mail: ub_info@inspection.gov.mn

2017. 03. 15 № 02-01/175
танай _____ -ны № _____ -т

ДАРГА **БАТЛАВ** Л.ЭРДЭНЭЧУЛУУН



Тэсрэх материалын хадгалалт,
хамгаалалтын байдалд хяналт
шалгалт хийх тухай

Нэг. Зорилго, үндэслэл

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын 2017 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу Нийслэлийн нутаг дэвсгэрт тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд болон хадгалах байр, агуулахын аюулгүйн бүс тогтоосон байдал, эрсдлийн түвшинд Монгол Улсын Төрийн хяналт шалгалтын тухай, Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай, Газрын тухай, Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай, Усны тухай, Хог хаягдлын тухай, Тамхины хяналтын тухай, Агаарын тухай хуулиуд болон тэдгээрт нийцүүлэн гаргасан норм, дүрэм, стандартын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн зөрчил дутагдлуудыг арилгуулах, эрсдлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хадгалах хугацаа дууссан чанар байдлаа алдсан тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг бүрэн устгалд оруулах зорилтыг хангахад энэхүү шалгалтын зорилго оршино.

Хоёр. Шалгалтын төрөл, арга, хэлбэр

Төлөвлөгөөт шалгалтыг дараах чиглэлүүдийн хүрээнд хийж гүйцэтгэнэ. Үүнд :

1. Уул уурхайн хяналтын чиглэлээр МХЕГ-ын даргын баталсан 2.9 кодтой "Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл, худалдах үйл ажиллагааг шалгах хяналтын хуудас"-аар,
2. Газрын харилцааны хяналтын чиглэлийг МХЕГ-ын даргын баталсан 2.12 кодтой "Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг шалгах хяналтын хуудас"-аар,
3. Байгаль орчны хяналтын чиглэлийг МХЕГ-ын даргын баталсан 2.23 кодтой

005050004681

“Үйлдвэрлэл, үйлчилгээ, үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх байдлыг шалгах хяналтын хуудас”-аар тус тус шалгана.

Гурав. Шалгалтын хүрээ, шалгалтад хамрагдах аж ахуйн нэгж, байгууллага, объектын нэр

Хяналт шалгалтад Мэргэжлийн хяналтын Ерөнхий газраас 2017 онд хяналт шалгалтад хамруулахаар зарлагдсан Нийслэлийн нутаг дэвсгэрт байрлах “Бласт” ХХК, “Мера” ХХК, “Фоорбласт” ХХК, “Илчтүлш” ХХК, “Нитросибирь монголиа” ХХК зэрэг 5 тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, болон хадгалах байр, агуулах хамрагдана.

Дөрөв. Шалгалтын бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагч

Хяналт шалгалтыг байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн геологи, уул уурхайн хяналтын улсын байцаагч Т.Амарсайхан ахалж, байгаль орчин, газар, геодези, зурагзүйн хяналтын улсын байцаагч Т.Эрдэнэболор, Агаарын бохирдлыг бууруулах газрын мэргэжилтэн нар хамтран хийж гүйцэтгэнэ.

Шалгалтын явцад Байгаль орчин, геологи, уул уурхайн хяналтын хэлтсийн дарга Д.Бат-Өлзий байнгын хяналт тавьж ажиллана.

Тав. Шалгалт эхлэх болон дуусах хугацаа

Төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2017 оны 05 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор, гүйцэтгэлийн хяналт шалгалтыг 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор хийж гүйцэтгэнэ.

Зургаа. Өмнө хийсэн шалгалтын талаарх мэдээлэл

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газраас төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдаж байгаагүй болно.

Долоо. Шалгалтаар хийж гүйцэтгэх ажлууд

Төлөвлөгөөт хяналт шалгалттай хамтатган “Тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэгчдэд хууль дүрмийг сурталчлах” сургалтыг 2017 оны 07 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулна.


Байгаль орчны хяналт:

- Уурхайн орчны агаарт Агаарын бохирдлын газартай хамтран шинжилгээт хяналт шалгалт хийх,

Долоо. Шалгалтын үр дүн, авах арга хэмжээ

Төлөвлөгөөт хяналт шалгалтын дүнг 2017 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн дотор нэгтгэж, газрын даргын дэргэдэх зөвлөлийн хурлын журамд заасны дагуу хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсний дараа ажлын 21 хоногт багтаан хурлаар хэлэлцүүлж, шийдвэрийг холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

Шалгалтын мэдээллийг МХЕГ-ын 2010 оны 107 тоот тушаалын “Олон нийтэд мэдээлэл түгээх журам”-д заасны дагуу хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилна.

ХЯНАСАН:
БАЙГАЛЬ ОРЧИН, ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.БАТ-ӨЛЗИЙ

БОЛОВСРУУЛСАН
ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙН
ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ  Т.АМАРСАЙХАН